



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/11/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
	Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Цэрэнханд
	Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn
	Аудитор: С.Санчирмаа
	Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.08.15 № 122

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар гэрээнд заасан хуваарьт хугацаанд үндсэн төлбөр, түрээсийн төлбөрийг төлүүлээгүй, нийгмийн даатгалын тайланд ажилчдын цалинг зөрүүтэй тайлагнасан, авлага, өглөгийн үлдэгдэл болон хоорондын тооцоо нийлээгүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг журмын дагуу хийгээгүй, орлогын төлөвлөгөө тасалсан зэрэг 388,712.4 мянган төгрөгийн зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 8 дугаар зүйлийн 8.4, 12 дугаар зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.3, 14.3.5, 20 дугаар зүйлийн 20.2.3 заалттай тус тус нийцэхгүй, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Үндсэн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 486,311.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Хөгжлийн банканд төлөх хуваарийг тогтоохдоо түрээслэгчээс авах жил бүрийн орлогын эх үүсвэрийг харгалзаж тооцоогүй, хүүг төлөх асуудлыг шийдвэрлээгүй зэргээс шалтгаалж 2023 онд орон сууцны үндсэн төлбөрийн 4,387,690.1 мянган төгрөгийн, хүүгийн 588,032.2 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

0702700390

Тайлант онд 4 зорилт 25 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 23 арга хэмжээг бүрэн, 1 арга хэмжээ 90.0 хувьтай, 1 арга хэмжээ 70.0 хувьтай буюу нийт дүнгээр 98.6 хувиар биелэлтийг хүргүүлсэн боловч ажлын дүгнээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	7,410,220.7	6,713,021.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,350,273.5	73,939.3
	Нийт хөрөнгийн дүн	8,760,494.2	6,786,960.7
	Нийт өр төлбөрийн дүн	7,132,754.1	6,354,045.2
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,627,740.1	432,915.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,760,494.2	6,786,960.7
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,564,017.9	260,154.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	140,557.7	180,978.8
	Үйл ажиллагааны үр дүн	1,423,460.1	79,175.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	4,500.0	(1,274,000.0)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,427,960.1	(1,194,824.5)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	199,780.0	1,627,740.1
	Тайлант оны үр дүн	1,427,960.1	(1,194,824.5)
	Эцсийн үлдэгдэл	1,627,740.1	432,915.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	830,512.3	818,917.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	147,059.9	177,897.1
	Үйл ажиллагааны ЦМГ	683,452.4	641,020.2
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(1,008,599.9)	(1,046,803.6)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(325,147.5)	(405,783.4)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,085,977.7	760,830.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	760,830.2	355,046.8
Зорилтод түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл			
	Нийт орлого	173,912.3	261,344.3
	Нийт зардал	143,510.3	180,978.8
	Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	30,402.0	80,365.5
	Орлогын албан татвар	3,040.2	8,036.5
	Татварын дараах ашиг алдагдал	27,361.8	72,329.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 1,420,186.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд 710.1 мянган төгрөгийн элэгдлийг зардлыг, өглөгийн дэлгэрэнгүй тайланд 11,077.8 мянган төгрөгийн өглөгийг, авлагын дэлгэрэнгүй тайланд 1,299,721.0 мянган төгрөгийн авлагыг, мөнгөн гүйлгээний тайланд 17,673.3 мянган төгрөгийн орлого, 2,218.2 мянган төгрөгийн зарлагыг, үр дүнгийн тайланд 51,226.2 мянган төгрөгийн орлого, 1,893.2 мянган төгрөгийн зарлагыг зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," гэж заасныг зөрчсөн байна.

Хууль тогтоомжтой холбоотой: Хувь хүний орлогын албан татварын тайланд 11,776.1 мянган төгрөгийн цалинг зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайланд 21,403.8 мянган төгрөгийн орлогыг дутуу, 2,486.4 мянган төгрөгийн зарлагыг илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.14-т "Энэ хуулийн 24.4-т заасны дагуу тодорхойлон ногдуулсан албан татварыг албан татвар төлөгч энэ хуульд заасан хугацаанд тайлагнана." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 388,712.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 388,712.4 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрч 322,269.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 63,763.9 мянган төгрөгийн зөрчил арилгах, 2,678.7 мянган төгрөгийн 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

1. Гэрээнд заасан хуваарьт хугацаанд 311,679.2 мянган төгрөгийн үндсэн төлбөр, 10,590.6 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг төлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"; Төрийн түрээсийн орон сууцанд орон сууц түрээслэх гэрээний 3.2-т "Гэрээний хавсралтад заасан төлбөр төлөлтийн хуваарийн дагуу төлбөрийг 2 сар төлөөгүй тохиолдолд сануулах ба 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тохиолдолд түрээслээд өмчлөгчтэй байгуулсан гэрээг цуцалж энгийн түрээсээр тооцож хуримтлуулсан урьдчилгаанаас тооцож авна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн төлбөр, түрээсийн төлбөрийг төлүүлж харилцах дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Албан шаардлага

1. Нийгмийн даатгалын тайланд 749.6 мянган төгрөгийн цалинг зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Албан хаагчдын цалинг нийгмийн даатгалын тайланд нөхөн тайлагнах албан шаардлага хүргүүлсэн.

2. Хөгжлийн банканд төлөх хуваарийг тогтоохдоо түрээслэгчээс авах жил бүрийн орлогын эх үүсвэрийг харгалзаж тооцоогүй, хүүг төлөх асуудлыг шийдвэрлээгүй, түрээслэгчээс төлсөн төлбөрийг дутуу төвлөрүүлсэн зэргээс шалтгаалж 2023 онд орон сууцны үндсэн төлбөрт 4,387,690.1 мянган төгрөгийн, хүүд 588,032.2 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Үл хөдлөх эд хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээний 2.3-т "Худалдан авагч зээлээр худалдан авсан үл хөдлөх хөрөнгийн үнийг Гэрээний Хавсралт 2-т тусгасан хуваарийн дагуу төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.3 хувиар тооцож, алданги ногдуулна" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Эдийн засгийн тооцоо судалгаа хийж Хөгжлийн банканд төлөх хугацаа хэтэрсэн зээлийг шийдвэрлэх арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлсэн.

3. Тайлант онд 5 байгууллагын 32,055.2 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдэл болон хоорондын тооцоог нийлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах албан шаардлага хүргүүлсэн.

4. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор бараа материалыг тоолоогүй, тооллогын комисс баталгаажуулаагүй, Няравын тайлан гаргаагүй. Нягтлан бодох бүртгэлийн программд журналын хөтлөлт хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг

баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Албан үүргээ хэрэгжүүлээгүй нягтлан бодогч, нярав нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

5. Тайлант хугацаанд бэлтгэсэн 7,068.9 мянган төгрөгийн материалыг бараа материалын тайланд орлого зарлагаар тайлагнаагүй. Няравын тайлан хөтлөөгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "Жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлагналын олон улсын стандарт;" 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах," гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хийж албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

												/ сая төгрөгөөр/	
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Алтай орон сууцны корпорац ААТҮГ	8	1,420.2	-	-	8	1,420.2	8	1,420.2	-	-	-	-	
Дүн	8	1,420.2	-	-	8	1,420.2	8	1,420.2	-	-	-	-	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Алтай орон сууцны корпорац ААТҮГ	6	364.8	1	322.3	4	42.5	1	2.7	-	-	-	-
Дүн	6	364.8	1	322.3	4	42.5	1	2.7	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНА		1				1		
	НИЙТ		1				1		